

Виз болон консулын хэлтсийн үйлчилгээний төлбөр, хураамж

Визийн болон консулын хэлтсийн үйлчилгээ төлбөртэй байна.

Монгол Улсад суугаа Бүгд Найрамдах Польш Улсын Элчин сайдын яамны Консулын хэлтэс нь виз болон консулын үйлчилгээний төлбөр, хураамжийг зөвхөн **ЕВРО-гоор бэлнээр** хүлээн авах бөгөөд дэвсгэртүүд нь ЯМАРВАА **НЭГЭН ГЭМТЭЛГҮЙ** байх шаардлагатай.

“Виз болон консулын хэлтсийн үйлчилгээний төлбөр, хураамж” хүснэгтийг ЭСЯ-ны Консулын газраас авах боломжтой.

Бусад хууль эрх зүйн актад дурьдсан хөнгөлөлт, чөлөөлөх заалт нь “Виз болон консулын хэлтсийн үйлчилгээний төлбөр, хураамж” хүснэгтэд дурьдсан төлбөрөөс чөлөөлөх үндэслэл болохгүй. Консулын газарт мэдүүлэг өгөхөөс өмнө “консулын мэдээлэл” хэсэгтэй сайтар танилцан “Виз болон консулын хэлтсийн үйлчилгээний хураамж” хүснэгтээс төлбөр төлөх дүнг харах боломжтой.

№	Үйлчилгээний төлбөр, хураамж	Евро
I.Паспорт		
1.01	Гадаад паспорт олгох	110,00
1.02	Гадаад паспорт олгох – 12-оос доош насны хүхэд (хүсэлт гаргасан өдөр 12 нас хүрээгүй байх)	35,00
1.03	2022 оны 1 дүгээр сарын 27-ны өдрийн “Паспорт болон түүнтэй адилтгах баримт бичгийн тухай хууль”-ийн 21 дүгээр зүйлийн 1 дүгээр заалтын 2-15, 16 С хэсэгт заасан иргэнд паспорт олгох	55,00
1.04	2022 оны 1 дүгээр сарын 27-ны өдрийн “Паспорт болон түүнтэй адилтгах баримт бичгийн тухай хууль”-ийн 21 дүгээр зүйлийн 1 дүгээр заалтын 16 А хэсэгт заасан иргэдэд паспорт олгох	18,00
1.05	2022 оны 1 дүгээр сарын 27-ны өдрийн “Паспорт болон түүнтэй адилтгах баримт бичгийн тухай хууль”-ийн 21 дүгээр зүйлийн 1 дүгээр заалтын 16 В хэсэгт заасан иргэдэд паспорт олгох	35,00
1.06	Түр хугацааны паспорт олгох	40,00
1.07	Шинээр паспорт олгох хүртэл ашиглах түр хугацааны паспорт олгох	15,00

1.08	Хоёр дахь паспорт олгох	220,00
II. Польшийн иргэншил авахтай холбоотой үзүүлэх үйлчилгээ		
2.01	Польш Улсын харьяат болох хүсэлтийн баримт бичиг боловсруулах, Польшийн харьяат болсон тухай захирамж эсхүл татгалзсан тухай мэдэгдэл өгөх*)	360,00
2.02	Иргэний харьяаллыг сэргээн тогтоох баримт бичиг боловсруулах, харьяаллыг сэргэн тогтоосон тухай захирамж олгох*)	40,00
2.03	Польш улсын харьяат мөн болохыг баталгаажуулах баримт бичиг боловсруулах, холбогдох захирамжийг олгох*)	80,00
2.04	Польш улсын харьяатаас гарах хүсэлтийн баримт бичиг боловсруулах, харьяатаас гарсан тухай захирамж олгох*)	360,00
2.05	2009 оны 4 дүгээр сарын 2-ны өдрийн “Польш Улсын харьяат байх тухай хууль”-ийн 9 дүгээр зүйлийн 2 дахь заалтыг үндэслэн баримт бичиг хүлээн авах (2018 оны Хуулийн эмхтгэл 1829 дүгээр хэсэг, 2019 оны Хуулийн эмхтгэл 730 дугаар хэсэг, Хуулийн эмхтгэл 1274 дүгээр хэсэг)	30,00
III. Гадаадын иргэн, харьяатад жижиг боомтоор нэвтрэх визийн мэдүүлэг авах болон бусад үйлчилгээ үзүүлэх		
3.01	Үндэсний виз хүсэх мэдүүлэг хүлээн авах шийдвэрлэх	135,00
3.02	Үндэсний виз шинээр дахин шийдвэрлүүлэх	135,00
3.03	Хилийн жижиг боомтоор нэвтрэх зөвшөөрөл хүсэх мэдүүлэг шийдвэрлүүлэх	20,00
3.04	Хилийн жижиг боомтоор нэвтрэх зөвшөөрөл шинээр дахин шийдвэрлүүлэх	20,00
3.05	Гадаадын иргэн, харьяатын Польшид түр зорчих баримт	30,00
3.06	Европын Зөвлөлийн 1996 оны 6 дугаар сарын 26-ны өдрийн 96/409/WPZiB тоот шийдвэрийг үндэслэн түр зорчих баримт олгох (1996 оны 07 дугаар сарын 6-ны өдрийн ЕХ-ны Хуулийн эмхтгэл 168 дугаар хэсэг, хуудас 4)	30,00
0.01	Шенгений виз хүсэх мэдүүлэг хүлээн авах шийдвэрлэх	90
3.07	Шенгений виз шинээр дахин шийдвэрлүүлэх	80
IV. Тодорхойлолт, зөвшөөрөл гаргах		

4.01	БНПУ-ын хилээр галт зэвсэг, сум оруулах эсхүл дамжин өнгөрөх тээвэр хийх болон Европын галт зэвсгийн жагсаалтад оруулах зөвшөөрөл хүсэх	60,00
4.02	БНПУ-ын хилээр нас барсан хүний цогцос эсхүл чандар оруулах эсхүл дамжин өнгөрөх тээвэр хийх дагалдах бичиг өгөх	50,00
4.03	Төлбөр, хураамж хүснэгт дэх 4.01 болон 4.02 дугаарт зааснаас бусад баримт бичиг, тодорхойлолт	30,00
V. Баримт бичиг хүлээн авах болон олголт		
5.01	Гадаадад оршин суугаа иргэний гаргасан хүсэлтэд Польшийн холбогдох төрийн байгууллагаас ирүүлсэн хариу баримт бичгийг олгох	30,00
5.02	Польш Улсын иргэний гаргасан хүсэлтийн (үнэт цааснаас бусад) хариу баримт бичгийг олгох (шаардлагатай тохиолдолд баримт бичгийг баталгаажуулна)	30,00
5.03	Тусгайлан заасан хууль, тогтоомжид тусгасан хугацаанд багтан иргэний гаргасан хүсэлтийг Консулаар уламжлан албан шугамаар холбогдох төрийн байгууллагад илгээх	20,00
5.04	Гадаадад цэргийн алба хаах эсхүл цэргийн байгууллагад ажиллах зөвшөөрөл олгох хүсэлт хүлээн авах болон хариу шийдвэрийг олгох	50,00
5.05	Хэргийн талаарх баталгаажсан шийдвэр эсхүл хуулбар олгох	30,00
VI. Бичиг барим баталгаажуулах, нотариатын үйлдэл, орчуулга гэрчлэх үйлчилгээ		
6.01	Баримт бичиг баталгаажуулах	30,00
6.02	Иргэний баримт бичгийн хуулбар үнэн зөвийг гэрчлүүлэх, баталгаажуулах үйлчилгээг эсхүл Консулын газарт хадгалагдаж буй Консулын нотариатын үйлдэл хийгдсэн баримт бичгийн хуулбарыг авах	60,00
6.03	Баримт бичгийн хуулбарын үнэн зөвийг баталгаажуулах эсхүл эх хувийн хуулбарыг гэрчлүүлэх	30,00
6.04	Гарын үсэг эсхүл гарын үсгийн тайллыг баталгаажуулах	30,00
6.05	Баримт бичгийн огноо баталгаажуулах	30,00
6.06	Баримт бичгийн нотариатын үйлдэл хийж нэмэлт нэг хувь олгох	260,00
6.07	Нотариатын бусад үйлчилгээ үзүүлэх	30,00

6.08	Польш хэлнээс суугаа орны албан ёсны хэлнээ эсхүл суугаа орны албан ёсны хэлнээс польш хэлнээ орчуулсан бичиг баримтын орчуулгыг хянаж баталгаажуулах - хуудас тус бүрээр**)	90,00
6.09	Польш хэлнээс суугаа орны албан ёсны хэлнээ эсхүл суугаа орны албан ёсны хэлнээс польш хэл рүү орчуулсан бичиг баримтын орчуулгыг хянаж баталгаажуулах - хуудас тус бүрээр**)	30,00
6.10	Давтагдсан агуулга бүхий бичиг баримтыг польш хэлнээс суугаа орны албан ёсны хэлнээ эсхүл тухайн орны албан ёсны хэлнээс польш хэлнээ хийсэн орчуулгыг хянаж баталгаажуулах (хуудас тус бүрээр)	50,00
VII. Иргэний гэр бүлийн байдалтай холбоотой үйлчилгээ		
7.01	Консулын газарт гэр бүл бүртгүүлэхтэй холбоотой баримт бичиг бүрдүүлэх, гэрлэсний дараа өөрийн болон энэхүү гэр бүлээс төрсөн хүүхдийн овог солих хүсэлт, мэдэгдлийг хүлээн авсан протокол зэргийг Польш улсын холбогдох иргэний бүртгэлийн байгууллагад хүргүүлэх, гэрлэлтийн гэрчилгээ олгох*),***)	500,00
7.02	Гэр бүл бологсдоос гэр бүл болоход харшлах шалтгаангүй болох тухай мэдэгдэл авч Польш Улсын холбогдох иргэний бүртгэлийн байгууллагад хүргүүлэх	50,00
7.03	Польш Улсын холбогдох хуулийн дагуу гэр бүл болоход харшлах шалтгаангүй болох тухай тодорхойлолт гаргах, олгох	50,00
7.04	Польш Улсын холбогдох хуулийн дагуу гэр бүл бүртгэхэд харшлах шалтгаан байхгүй тухай тодорхойлолтыг Польш Улсын холбогдох иргэний бүртгэлийн байгууллагаас гаргуулах, олгох***)	50,00
7.05	Хүүхдийн эцэг тогтоолгоход шаардлагатай бичиг баримт хүлээж авах, тодорхойлолт гаргах, Польш Улсын холбогдох иргэний бүртгэлийн байгууллагад хүргүүлэх	50,00
7.06	Галиглан бичихтэй холбоотой бичиг баримт боловсруулах, гадаадад оршин суугаа Польш Улсын харяатад польшийн иргэний бүртгэлийн байгууллагаас олгосон бичиг баримтын хуулбар олгох *),***)	50,00
7.07	Төрсний, нас барсны бүртгэлд бүртгүүлэх хүсэлт хүлээн авах, Польш Улсын холбогдох иргэний бүртгэлийн байгууллагад хүргүүлэх, төрсний, нас барсны гэрчилгээний хуулбар олгох***)	50,00

7.08	Иргэний овог, нэр сольсон тухай мэдээлэл хүлээн авч Польшийн иргэний бүртгэлийн холбогдох байгууллагад хүргүүлэх	50,00
7.09	Иргэний овог, нэр солих хүсэлт хүлээн авах, Польшийн холбогдох иргэний бүртгэлийн байгууллагад хүргүүлэх, шийдвэрийг олгох	50,00
7.10	Иргэний бүртгэлтэй холбоотой бусад үйлчилгээ	30,00
VIII. Далайн болон усан боомтын тээврийн асуудлаарх үйлчилгээ		
8.01	Польш Улсын хөлөг онгоцны бүртгэлд бүртгэгдсэн гэрчилгээ олгох (далбааны эзэн улсын гэрчилгээ)	240,00
8.02	Далайн тээврийн хөлөг онгоцны ахмадаас мэдэгдэл хүлээн авах, ослын талаар протокол үйлдэх	300,00
8.03	Усан онгоц бохирдолгүй болохыг баталсан гэрчилгээ олгох эсхүл хугацааг батлах, аюулгүй байдлыг хангасан болохыг тодорхойлсон гэрчилгээ олгох, гэрчилгээний хугацаа сунгах	200,00
8.04	Далайн болон усан боомтын тээврийн асуудлаарх бусад үйлчилгээ	40,00
IX. Онцгой нөхцөлд үзүүлэх үйлчилгээ****)		
9.01	Хүсэлт гаргагч талд Консулын газраас гадна үзүүлэх үйлчилгээ (очих, буцах цагийг оруулан ажлын 8 цаг тутамд)	90,00
9.02	Энэхүү жагсаалтад дурьдсан үйлчилгээг яаралтай горимоор шийдвэрлэхэд	30,00

*) Орчуулга хийх, хянаж баталгаажуулах зэргээс бусад бичиг баримт боловсруулахад консулын үйлчилгээний нэмэлт төлбөр авахгүй (Консулын үйлчилгээний тарифын 6.08, 6.09 , 6.10, 6.11 хэсэг) болно.

**) Бичиг баримтын хуудас тоо хэмжээнээс шалтгаалан үйлчилгээний хураамжийг албан ёсны орчуулагчийн орчуулгын төлбөр тооцооны журмын дагуу тогтоож тооцно.

***) Баталгаажуулалт хийлгэх эсхүл Апостиль гэрчилгээ авсан байх.

****) Онцгой нөхцөлд үзүүлэх үйлчилгээний төлбөрийг консулын үйлчилгээний хураамжийн хамт тооцно.